



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 12 сарын 07 өдөр

Дугаар А/546

Мандлговь

Аймгийн "Шилдэг санхүүч, эдийн засагч"-ийг шалгаруулж, урамшуулах тухай

Монгол Улсын "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай" хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 "а", аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.1.4, аймгийн Засаг даргын 2017 оны А/407 дугаар захирамжаар батлагдсан "Шилдэг төрийн албан хаагч шалгаруулж, урамшуулах журам"-ын 4.1 дэх заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн 17 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. 2018 оны аймгийн "Шилдэг санхүүч, эдийн засагч"-аар Дундговь аймгийн Төрийн аудитын газрын аудитор Баяраа овогтой Гантуяа, Луус сумын Санхүүгийн албаны дарга Жамба овогтой Ундрахбаяр нарыг шалгаруулж тус бүр өргөмжлөл, 1,000,000 (нэг сая) төгрөгөөр шагнаж урамшуулсугай.

Хоёр. Шилдэг санхүүч, эдийн засагчийн урамшууллын зардлыг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

Гурав. Шагналын зардалд шаардагдах 2.097.000 (хоёр сая ерэн долоон мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Эрдэнэсүрэн), нягтлан бодогч (Д.Нандинцэцэг) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

438010678

Аймгийн Засаг даргын 2018 оны
12 дугаар сарын 07-ний өдрийн 1546 тоот
захирамжийн 1 дугаар хавсралт



ШИЛДЭГ БАГШ УРАМШУУЛАХ, УРАМШУУЛЛЫН ЗАРДАЛ

| № | Зардлын утга | Тоо ширхэг | Нэг бүрийн үнэ | Бүгд үнэ |
|---|--------------|------------|----------------|-----------|
| 1 | Урамшуулал | 2 | 1,000,000 | 2,000,000 |
| 2 | Өргөмжлөл | 2 | 42,000 | 84,000 |
| 3 | Батламж | 2 | 6,500 | 13,000 |
| 4 | ДҮН | | | 2,097,000 |